bee financial group | non-bank financial institution

"Зөгий санхүүгийн групп ББСБ" ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн ТУЗ/24-01-03 дугаар тогтоолын хавсралт №5

"ЗӨГИЙ САНХҮҮГИЙН ГРУПП ББСБ" ХХК-ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот
2024 он

Танилцах: Зөгий санхүүгийн гурпп ББСБ ХХК-ийн бүх ажилтнууд болон оролцогч талууд	Хариуцах эзэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Хүчинтэй хугацаа: 2024 оны 01-р сарын 15-ны өдрөөс эхлэн	Хуудасны тоо: …… хуудас
Журмын дугаар: ТУЗ/24-01-03 тоот тогтоолын хавсралт №5	Хувилбар: v-1.0

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
3. ОРОЛЦОГЧ ТАЛУУД
4. БУСАД

ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү баримт бичгээр "Зөгий санхүүгийн групп ББСБ" ХХК (цаашид "компани" гэх)- ийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг тодорхойлох бөгөөд бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, компанийн ажилтан, харилцагч, хэрэглэгч, үйлчлүүлэгч зохицуулагч, төрийн болон бусад байгууллагатай хэрхэн харилцах, хамтын ажиллагааг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, журам, зааварт нийцүүлэн боловсруулав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. ТУЗ энэхүү бодлогын баримт бичгийг батлах бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороогоор дамжуулан хяналт тавьж ажиллана.

2.2. Компани оролцогч талуудад компанийн үйл ажиллагаанд холбогдох мэдээллийг нээлттэй, ил тод хэлбэрээр хүргүүлэх, оролцогч талуудаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, тэдгээрийн дагуу тодорхой ажил зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд компанийн эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулан хариу өгөх үйл ажиллагааг зохион байгуулах замаар бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3. Энэхүү бодлогын хүрээнд компанийн үйл ажиллагаа, оролцогч талуудтай харилцах харилцаанд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхийг зорино.

2.4. Компани оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа хүний эрхийг хүндэлж, хүний эрхийг зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

2.5. Компани оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа компанийн цахим хуудас болон олон нийтийн сүлжээн дэх хаягийг үр дүнтэйгээр ашиглана.

2.6. Бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхийг эрмэлзэнэ. Үүнд:

2.6. 1 . Оролцогч талууд болон тэдгээрийн үйлчлүүлэгч, харилцагчдын эрх ашигт хүндэтгэлтэй хандаж, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх, харилцааны зөв хэв маягийг хэвшүүлэх, цаашдын хамтын ажиллагааг тодорхойлох;

2.6.2. Оролцогч талуудыг цаг тухайд нь үнэн зөв, бодит мэдээллээр хангах;

2.6.3. Хөрөнгө оруулагчидтай харилцах сайн засаглалд нийцсэн мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, компанийн үнэ цэн болон засаглалыг сайжруулах.

ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

3.1. Хувьцаа эзэмшигч:

3.1.1. Хувьцаа эзэмшигчийг компанийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэгч гэдэг утгаар нь түүний хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн тэгш хандаж, компанийн талаар мэдээлэл авах болон хууль болон компанийн дүрэмд заасан эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрэн хангаж, ТУЗ хэрэгжилтэд хяналт тавина.

3.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хүндэтгэнэ.

3.2. Хөрөнгө оруулагч:

3.2.1. Хөрөнгө оруулагчдад компанийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийг ойлгомжтой, хялбар байдлаар мэдээллийг цахим сувгаар нийтэлнэ.

3.2.2. Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг ТУЗ баталж, хэрэгжилтийг хангуулна.

3.3. Ажилтан:

3.3.1.Ажилтныг компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэдэг утгаар нь түүнтэй харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд харилцана.

3.3.2. Ажилтныг ажлаа чөлөөтэй сонгох, эрүүл, аюулгүй орчинд ажиллах, цалин хөлс шударгаар тогтоолгох эрхийг хүндэтгэж, эрхийг зөрчигдөхөөс хамгаалж, зөрчигдсөн тохиолдолд нэн дариу илрүүлж, эрхийг эдлүүлнэ.

3.3.3. Хөдөлмөрийн дотоод журамд ажилтны эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх зохицуулалтыг тусгах ба хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй байх;

3.3.4. Ажилтны гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ ажилтанд ашигтай байдлаар шийдэх.

3.4. Хэрэглэгч, харилцагч:

3.4.1 Хэрэглэгч, харилцагчийг компанийн орлогыг бүрдүүлэгч гэсэн утгаар нь тэдний хэрэгцээг чанар, тоон үзүүлэлтээр бүрэн хангах, тэдний эрхийг хамгаалах зорилго бүхий байгууллагын соёлыг бүрдүүлж ажиллана.

3.4.2. Хэрэглэгч, харилцагчтай харилцах харилцаанд гарсан зөрчил, маргааныг эв зүйгээр тохиролцож, компанийн гомдол барагдуулах журамд заасны дагуу харилцан буулт хийх замаар шийдэх, харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлэх.

3.5. Зохицуулагч байгууллага болон төрийн байгууллага:

3.5.1. Зохицуулагч байгууллага, төрийн байгууллагад хүргүүлэх тайлан мэдээг холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангасан хэлбэрээр, цаг тухайд нь хүргүүлнэ.

3.5.2. Компани зохицуулагч байгууллага болон төрийн байгууллагатай харилцахдаа хууль тогтоомжийн хүрээнд харилцана.

3.5.3 Зохицуулагч байгууллага, төрийн байгууллагатай харилцах харилцаанд цахим хэрэгслийг түлхүү ашиглана.

3.5.4 Төрийн байгууллага, зохицуулагч байгууллагын хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

3.6. Санал, хүсэлт хүлээн авах.

3.6.1. Компанийн албан мэйл болох info@beegroup.mn, олон нийтийн сүлжээн дэх https://www.facebook.com/beegroup.mn цахим хаягаар дамжуулан цахим хэлбэрээр;

3 .6.2.Компанийн лавлах утас 7222-1155 дугаарт холбогдон аман хэлбэрээр;

3.6.3.Компанид өөрийн биеэр ирж цаасаар санал хүсэлтээ өгнө.

3.7. Оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг оффис менежер ажилтан хүлээн авч холбогдох ажилтанд шилжүүлэх бөгөөд ажлын 7 хоногийн дотор холбогдох хариуг өгнө.

3.8.Оролцогч талуудаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ мэдээллийн нууцлалыг хангаж, хүний эрхийг хүндэтгэх зарчмыг баримтална.

ДӨРӨВ. БУСАД

4.1. ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт , өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

“ЗӨГИЙ САНХҮҮГИЙН ГРУПП ББСБ” ХХК